



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠭᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/221

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай 11 дүгээр зүйлийн хуулийн 11.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 18 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.1.6, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, төсвийн байгууллага болох Нэгдсэн эмнэлгийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор аймгийн Засаг даргад ирүүлсэн, тус байгууллагын цахим серверийг шинэчлэх хүсэлтийг харгалзан дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах 34,000,000 (гучин дөрвөн сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР